

**ДАРХАН СЭЛЭНГИЙН ЦАХИЛГААН ТҮГЭЭХ СҮЛЖЭЭ ХУВЬЦААТ КОМПАНИ**  
**ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ**

---

2019 оны 3-р сарын 1-ний өдөр

Дугаар 03/01

Улаанбаатар хот

Төслийн санхүүжилтийн асуудлыг  
хувьцаа эзэмшигчдийн хуралд танилцуулах  
тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.3, 76.1.18, 80 дугаар зүйлийн 80.2 дахь хэсэг, “Дархан Сэлэнгийн Цахилгаан Түгээх Сүлжээ” хувьцаат компани (цаашид "Компани" гэх)-ийн дүрмийн 7 дугаар зүйлийн 7.32.4 дэх хэсэг болон 7.34 дэх хэсэг, Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид "ТУЗ" гэх)-ийн 2019 оны 3 дугаар сарын 1-ний өдрийн хурлын тэмдэглэлийг үндэслэн ТОГТООХ нь:

Нэг. 20 мегаватын нарны цахилгаан станцын төсөл (цаашид “Төсөл” гэх)-ийн санхүүжилтийн бүтэц, хэмжээ, схемийг хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлсүгэй.

Хоёр. Төслийн санхүүжилтийн хүрээнд нэмэлт энгийн хувьцаа, давуу эрхийн хувьцаа гаргах асуудлыг хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцэн шийдвэрлүүлсүгэй.

Гурав. Энэхүү тогтоолын биелэлтийг хангаж ажиллахыг Компанийн ТУЗ-ийн Нарийн бичгийн дарга (М.Баярманла)-д үүрэг болгосугай.

ХУРАЛ ДАРГАЛАГЧ



Г.БЭХБАТ

**ДАРХАН СЭЛЭНГИЙН ЦАХИЛГААН ТҮГЭЭХ СҮЛЖЭЭ ХУВЬЦААТ КОМПАНИ**  
**ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ**

---

2019 оны 3-р сарын 1-ний өдөр

Дугаар 03/02

Улаанбаатар хот

Аудитын тайланг хэлэлцэн батлах тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.11, 80 дугаар зүйлийн 80.2 дахь хэсэг, Аудитын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2.1, “Дархан Сэлэнгийн Цахилгаан Түгээх Сүлжээ” хувьцаат компани (цаашид "Компани" гэх)-ийн дүрмийн 7 дугаар зүйлийн 7.32.5 дахь хэсэг болон 7.34 дэх хэсэг, Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид "ТУЗ" гэх)-ийн 2019 оны 3 дугаар сарын 1-ний өдрийн хурлын тэмдэглэлийг үндэслэн ТОГТООХ нь:

Нэг. Хараат бус аудитын тайлан (Хавсралт 1)-г хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд танилцуулсугай.

Хоёр. Энэхүү тогтоолын биелэлтийг хангаж ажиллахыг Компанийн ТУЗ-ийн Нарийн бичгийн даргад үүрэг болгосугай.

ХУРАЛ ДАРГАЛАГЧ



Г.БЭХБАТ

## ДАРХАН СЭЛЭНГИЙН ЦАХИЛГААН ТҮГЭЭХ СҮЛЖЭЭ ХУВЬЦААТ КОМПАНИ

### ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2019 оны 3-р сарын 1-ний өдөр

Дугаар 03/03

Улаанбаатар хот

Ногдол ашиг олгох тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1, 76 дугаар зүйлийн 76.1.12, 80 дугаар зүйлийн 80.2 дахь хэсэг, “Дархан Сэлэнгийн Цахилгаан Түгээх Сүлжээ” хувьцаат компани (цаашид “Компани” гэх)-ийн дүрмийн 7 дугаар зүйлийн 7.32.5 дахь хэсэг болон 7.34 дэх хэсэг, Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид “ТУЗ” гэх)-ийн 2019 оны 3 дугаар сарын 1-ний өдрийн хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

Нэг. Компанийн үйл ажиллагаа, санхүүнийн тайлан, төлөвлөгөө Компанийн ТУЗ-ийн Аудитын хорооны дүгнэлтийг үндэслэн 2018 оны үйл ажиллагаагаар нэгж хувьцаанд 1 төгрөг 10 мөнгөний ногдол ашиг олгосугай.

Хоёр. Ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2019.03.21, ногдол ашиг төлөх өдрийг 2019.07.02-ний өдөр байхаар тогтоосугай.

Гурав. Энэхүү тогтоолын биелэлтийг хангаж ажиллахыг Компанийн ТУЗ-ийн Нарийн бичгийн даргад үүрэг болгосугай.

ХУРАЛ ДАРГАЛАГЧ



Г.БЭХБАТ

**ДАРХАН СЭЛЭНГИЙН ЦАХИЛГААН ТҮГЭЭХ СҮЛЖЭЭ ХУВЬЦААТ КОМПАНИ**  
**ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ**

2019 оны 3-р сарын 1-ний өдөр

Дугаар 03/04

Улаанбаатар хот

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлан хуралдуулах тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.2, 80 дугаар зүйлийн 80.2 дахь хэсэг, Дархан Сэлэнгийн Цахилгаан Түгээх Сүлжээ хувьцаат компани (цаашид “Компани” гэх)-ийн дүрмийн 7 дугаар зүйлийн 7.32.5 дахь хэсэг болон 7.34 дэх хэсэг, Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид “ТУЗ” гэх)-ийн 2019 оны 3 дугаар сарын 1-ний өдрийн хурлын тэмдэглэлийг үндэслэн ТОГТООХ нь:

Нэг. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал (цаашид “Хурал” гэх)-ыг 2019 оны 4 дүгээр сарын 11-ний өдрийн 11 цагт “Хасвуу” плазагийн хурлын танхимд хуралдуулсугай.

Хоёр. Хурлаар дараах асуудлыг хэлэлцсүгэй: (i) Компанийн 2018 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлт бүхий тайланг батлах, (ii) Компанийн ТУЗ-өөс баталсан 2019 оны бизнес төлөвлөгөөг хэлэлцэх, (iii) Компанийн ногдол ашгийн талаар гаргасан ТУЗ-ийн шийдвэрийг танилцуулах, (iv) Компанийн ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох, (v) Компанийн ТУЗ-ийн 2019-2020 оны цалин урамшуулал болон зардлыг батлах, (vi) Компанийн давуу эрхийн хувьцаа гаргах, энгийн хувьцаа нэмж гаргах эсэх асуудлыг хэлэлцэн батлах, (vii) Компанийн давуу эрхийн хувьцаа гаргах, энгийн хувьцаа нэмж гаргах шийдвэрийг гаргасан тохиолдолд Компанийн дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах.

Гурав. Хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2019 оны 3-р сарын 21-ний өдрөөр тогтоосугай.


Дөрөв. Хурал хуралдуулах тухай хувьцаа эзэмшигчдэд мэдэгдэх өдрийг 2019 оны 3-р сарын 6-ны өдрөөр тогтоон, Санхүүгийн зохицуулах хорооны 2018 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн 377 дугаар тогтоолын хавсралтаар баталсан Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журамд нийцүүлэн хувьцаа эзэмшигчдэд мэдэгдсүгэй.

Тав. Хувьцаа эзэмшигчид нь Компанийн 2018 оны үйл ажиллагааны тайлан, санхүүгийн тайлан тэнцэл болон, Компанийн 2019 оны бизнес төлөвлөгөө, Компанийн давуу эрхийн хувьцаа гаргах талаарх мэдээлэл, Хувьцаа эзэмшигчдийн хурлын тогтоолын төсөл болон холбогдох бусад мэдээлэлтэй танилцаж болно.

Зургаа. Хурлын даргаар Г.Бэхбатыг томилсугай. Тооллогын комиссын даргаар ТУЗ-ийн хараат бус гишүүн Л.Балган, гишүүдээр Ц.Баярбаатар, Э.Долгорсүрэн, М.Баярманла нарыг тус тус томилсугай.

Долоо. Саналын хуудасны агуулгыг хавсралт ёсоор батлан, саналын хуудсыг авах сүүлчийн өдрийг 2019 оны 4 дүгээр сарын 11-ны өдрөөр тогтоосугай.

ХУРАЛ ДАРГАЛАГЧ



Г.БЭХБАТ

**ДАРХАН СЭЛЭНГИЙН ЦАХИЛГААН ТҮГЭЭХ СҮЛЖЭЭ ХУВЬЦААТ КОМПАНИ**  
**ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ**

---

2019 оны 3-р сарын 1-ний өдөр

Дугаар 03/05

Улаанбаатар хот

Хэлцлийг батлах тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 82 дугаар зүйлийн 82.1 дэх хэсэг, Дархан Сэлэнгийн Цахилгаан Түгээх Сүлжээ хувьцаат компани /цаашид "Компани" гэх/-ийн Төлөөлөн удирдах зөвлөл /цаашид "ТУЗ" гэх/-ийн 2019 оны 03 дугаар сарын 1-ний өдрийн хурлын тэмдэглэлийг үндэслэн ТОГТООХ нь:

Нэг. Дархан Уул аймгийн шарын гол сумын 1-р багт Хайрхан 1 байрны 6 тоотод байрлах /Гэрчилгээний дугаар 000402611, Улсын бүртгэлийн дугаар Ү- 2001000223/ орон сууцны зориулалттай 29,34 мкв үл хөдлөх хөрөнгийг Компанийн хөрөнгөөс хасан Нямгараа овогтой Лхагвасүрэнгийн нэр дээр шилжүүлэхийг зөвшөөрсүгэй.

Хоёр. Энэхүү Тогтоолд дурдсан хөрөнгийг Н.Лхагвасүрэнгийн нэр дээр бүртгүүлэх ажлыг зохион байгуулах, Компанийг төлөөлөн төрийн эрх бүхий байгууллагад хандан бүртгэлийн ажлыг хийж гүйцэтгэхийг Компанийн Хяналт шинжилгээ аюулгүй ажиллагааны хэлтсийн дарга Чойжин овогтой Чинцогт /РД: ЙП 85020517/- д дуулгасугай.

ХУРАЛ ДАРГАЛАГЧ



Г.БЭХБАТ